

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 05 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС:

“Хариуцлагатай газрын харилцаа” 2 сарын аяны хүрээнд сумдын багийн Засаг дарга нар болон нийгмийн ажилтнуудад Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, төлөвлөлтүүдийн бичиг баримтуудын уялдаа холбоог хангах, Хаягжуулалтын тухай хуулийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр сургалт зохион байгуулан ажиллалаа.

Сургалтад нийт 10 багийн Засаг дарга болон 3 багийн нийгмийн ажилтнууд хамрагдаж харилцан мэдээлэл солилцож цаашдын ажлын уялдаа холбоог сайжруулахад хэрхэн хамтарч ажиллах талаар зөвшилцөж ажиллалаа.



Байгууллагын даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн баталсан “Албан байгууллагуудад газрын харилцааны талаар мэдээлэл хийх хуваарь”-ийн 8 албан байгууллагын 76 албан хаагчдад мэдээллийн цагийг хийн 142 ширхэг гарын авлага, зөвлөмжийг тарааж ажилласан. Мэдээллийн цагаар дараах чиглэлээр мэдээлэл хийн ажилласан. Үүнд:

- I. Малчдын хоршоонд газар эзэмшүүлэх талаар
- II. Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хадгалалт, хамгаалалт
- III. Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүд
- IV. Газар зүйн нэрийн мэдээллийн сан, хувийн хэрэгжүүлэх талаар
- V. Аймгийн хэмжээнд Хот тосгон бусад суурины тэг гортиг шинэчлэгдсэн
- VI. Сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө /ЗГ-ын 2024 оны 136 дугаар тогтоол/






Мөн 2024 оны 05 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Мөнх, Уулзвар, Малх, багууд, 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Найрамдал багийн өдөрлөгт Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд газрын харилцааны зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулга хийн 598 иргэддэд мэдээлэл хийж 254 ширхэг гарын авлага тараан ажилласан.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хорьдугаар хуралдаанаар 2024 оны орон нутгийн төсөвт сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгүүлэхээр 93.2 сая төгрөг, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийлгүүлэхээр 74.0 сая.төгрөгийг тус тус батлуулсан бөгөөд дээрх ажлыг хийж гүйцэтгэхээр Ланд овнер ХХК нь шалгарсан.

“Ланд овнер” ХХК нь дээрх ажлын эхний үе шат болох хээрийн тодруулалт, иргэдээс судалгаа авах ажил болон сумдын ажлын хэсгүүдтэй уулзалт зохион байгуулах ажлыг 2024 оны 05 дугаар сарын 07, 13-ны өдрүүдэд хийсэн.



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС:

1. Аймгийн Онцгой байдлын газартай хамтран орон нутагт барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Үүнд:


- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
- Галын аюулгүй байдал
- Хуулийн хэрэгжилт
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, аюулгүй ажиллагаа
- Үйлдвэр цехийн холбогдох баримт бичиг зэрэгт үзлэг шалгалтыг хийж заавар, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.



2. 2024 оны 05 дугаар сарын байдлаар дараах 2 объектод лабораторын шинжилгээ хийгдсэн байна. Үүнд:

2.1. Баянтал сумын 154-р байрны дээврийн ажлын ус тусгаарлах хуйлмал материалыг БХТ-н лабораторид шинжилгээнд хамруулсан.

2.2. Шивээговь сумын 6.9 км хатуу хучилттай авто замын ажлын бетон сорьцод байгууллага шинжилгээ хийсэн.



3. Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох баримт бичгийг хянаж, Urban.gov.mn кадастрын цахим систем болон цаасан хэлбэрээр олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар барилга байгууламжийн ажил үргэлжлүүлэх сунгалт хийгдсэн 6 объект, шинээр ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон 4 объект байна.

4. 2024 оны 05 дугаар сарын байдлаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 13,8 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 барилга байгууламжийн ажил хийгдэж байна. Үүнээс Шивээговь сумын 6,9км автозамын ажил, Сүмбэр сумын 2-р багт баригдсан Халуун усны барилга зэрэгт ажлыг эрчимжүүлэх, үүрэг даалгаварын биелэлт хангах талаар албан бичгийг хүргүүлэн ажилласан.



ТАЙЛАН НЭГТЭГСЭН АЖИЛТАН:

Т.УРАНТОГОС